



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 9/132

Улаанбаатар хот

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн
хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга
хэмжээний санал авах ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/487 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг иргэд, олон нийтээс авах үйл ажиллагааг цахим хэлбэрээр буюу гар утасны аппликейшн ашиглан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Санал авах ажилд иргэд, олон нийтийн оролцоог сайтар хангаж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

4. Тус ажлын хүрээнд ухаалаг утасны аппликейшний хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулах, иргэдэд хэрэгцээт мэдээллийг шуурхай хүргэх, иргэдээс санал авах зэрэг арга хэмжээг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулж, шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010443

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны
...09 дүгээр сарын ...14... ны өдрийн
...11/22 дугаар захирамжийн хавсралт

ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга
- Ажлын хэсгийн гишүүд: Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасгийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Тохижилт, байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн
- Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Зам, замын байгууламж хариуцсан мэргэжилтэн
- Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасгийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн